



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Прокурорын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/167/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Д.Эрдэнэцэцэг

Утас: 99019943

Цахим хаяг: erdenetsetseg.d@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	15
3.5.3 Нэмэлт төсөв	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Залруулсан алдаа	17
5.2 Төлбөрийн акт	17
5.3 Албан шаардлага	17
5.4 Зөвлөмж	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
МУЕП	Монгол улсын ерөнхий прокурор
ХШУДАГ	Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар

1 ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ПРОКУРОРЫН ГАЗРЫН ТАМГЫН
ДАРГА Д.ГАНЧИМЭГ ТАНАА

2023.02.18 № 02/55
танай _____ -ны № _____ -Т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Прокурорын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Прокурорын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан ажлаа бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсноор тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

АДБОУС 2706.10-д зааснаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүссэнгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

021020210

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>19,268,291.00</u>	<u>18,956,620.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	5,000,000.00	5,000,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	5,000,000.00	5,000,000.00
3121	Төгрөг	5,000,000.00	5,000,000.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	5,000,000.00	5,000,000.00
33	АВЛАГА	387,122.00	-
335	Бусад авлага	387,122.00	-
3351	Байгууллагаас авах авлага	387,122.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	13,881,169.00	13,956,620.00
354	Хангамжийн материал	13,881,169.00	13,956,620.00
35410	Бичиг хэргийн материал	885,200.00	340,000.00
35420	Аж ахуйн материал	145,949.00	67,200.00
35470	Бусад хангамжийн материал	12,850,020.00	13,549,420.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,853,624,733.05</u>	<u>1,845,060,181.07</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,853,624,733.05	1,845,060,181.07
392	Биет хөрөнгө	1,794,238,733.05	1,784,519,181.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,681,029,985.00	1,681,029,985.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(67,726,043.29)	(98,065,624.93)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	82,900,000.00	37,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(71,150,000.00)	(11,750,000.02)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	109,610,326.76	138,169,876.76
39206	Хуримтлагдсан элэгдэл	(17,160,344.78)	(38,441,520.75)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	97,538,740.74	107,548,740.74
39208	Хуримтлагдсан элэгдэл	(20,935,482.38)	(31,103,826.73)
39217	Ном	131,551.00	131,551.00
393	Биет бус хөрөнгө	59,386,000.00	60,541,000.00
39301	Програм хангамж	715,000.00	1,485,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(715,000.00)	(330,000.00)

39303	Бусад биет бус хөрөнгө	59,386,000.00	59,386,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,872,893,024.05</u>	<u>1,864,016,801.07</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,000,000.00	5,000,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,000,000.00	5,000,000.00
414	Урьдчилж орсон орлого	5,000,000.00	5,000,000.00
41430	Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	5,000,000.00	5,000,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,867,893,024.05</u>	<u>1,859,016,801.07</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,867,893,024.05	1,859,016,801.07
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	218,880,655.00	218,880,655.00
51101	Өмч: - төрийн	218,880,655.00	218,880,655.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,599,947,013.73	1,591,070,790.75
51210	Өмнөх үеийн үр дүн	1,599,947,013.73	1,599,947,013.73
51220	Тайлант үеийн үр дүн	-	(8,876,222.98)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	49,065,355.32	49,065,355.32
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,872,893,024.05</u>	<u>1,864,016,801.07</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	764,670,788.00	769,954,650.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	49,643,888.00	44,279,750.00
120	Нийтлэг татварын бус орлого	49,643,888.00	44,279,750.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	49,643,888.00	44,279,750.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	49,643,888.00	44,279,750.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	715,026,900.00	725,674,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	714,991,900.00	723,687,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	714,991,900.00	723,687,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	35,000.00	1,987,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,987,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	35,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	693,116,560.42	769,506,872.98

21	УРСГАЛ ЗАРДАЛ	693,116,560.42	769,506,872.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	681,241,485.17	728,337,603.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	452,704,263.87	475,676,479.30
210101	Үндсэн цалин	327,020,213.73	287,842,836.78
210102	Нэмэгдэл	100,384,052.50	151,058,937.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,299,997.64	25,463,574.00
210104	Урамшуулал	-	11,311,131.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,902,102.88	59,026,053.30
210201	Тэтгэврийн даатгал	39,350,918.36	40,154,513.42
210202	Тэтгэмжийн даатгал	4,387,795.63	4,717,884.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,510,235.90	3,774,307.92
210204	Ажилгүйдлийн даатгал	877,558.73	943,576.88
210205	Эрүүл мэндийн даатгал	8,775,594.26	9,435,770.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,846,078.00	36,634,320.00
210301	Гэрэл, цахилгаан	3,762,878.00	4,688,522.00
210302	Түлш, халаалт	28,500,000.00	28,360,598.00
210303	Цэвэр, бохир ус	3,583,200.00	3,585,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	36,284,708.00	30,665,553.00
210401	Бичиг хэрэг	12,126,000.00	8,996,200.00
210402	Тээвэр, шатахуун	10,072,051.00	12,325,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,591,806.00	3,538,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	407,860.00	951,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,086,991.00	4,854,553.00
2105	Нормативт зардал	-	1,500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,685,300.00	11,751,000.00
210604	Урсгал засвар	18,685,300.00	11,751,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,223,900.00	6,989,100.00
210702	Дотоод албан томилолт	2,223,900.00	6,989,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,834,891.00	13,826,096.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,272,700.00	13,146,396.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	636,900.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	185,700.00	185,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	242,000.00	-
210807	Газрын төлбөр	129,591.00	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	60,760,241.42	92,269,001.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,013,800.00	6,148,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,590,000.00	15,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	50,156,441.42	71,120,101.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,875,075.25	41,169,269.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	562,242.00	1,340,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	562,242.00	1,340,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,312,833.25	39,829,269.40
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,312,833.25	39,829,269.40
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>71,554,227.59</u>	<u>447,777.02</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	9,324,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(9,324,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>71,554,227.59</u>	<u>(8,876,222.98)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>720,026,900.00</u>	<u>725,674,900.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,000,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	5,000,000.00	-
120009	Бусад орлого	5,000,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	715,026,900.00	725,674,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	714,991,900.00	723,687,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	714,991,900.00	723,687,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	35,000.00	1,987,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,987,000.00

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	35,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	715,026,900.00	725,674,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	715,026,900.00	725,674,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	703,214,066.75	684,505,630.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	452,704,288.50	475,676,479.30
210101	Үндсэн цалин	301,526,200.00	287,842,836.78
210102	Нэмэгдэл	126,888,816.50	151,058,937.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,289,272.00	25,463,574.00
210104	Урамшуулал	-	11,311,131.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,902,078.25	59,026,053.30
210201	Тэтгэврийн даатгал	39,567,409.65	40,154,513.42
210202	Тэтгэмжийн даатгал	4,333,667.15	4,717,884.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,466,933.59	3,774,307.92
210204	Ажилгүйдлийн даатгал	866,733.56	943,576.88
210205	Эрүүл мэндийн даатгал	8,667,334.30	9,435,770.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,233,200.00	36,247,198.00
210301	Гэрэл, цахилгаан	4,150,000.00	4,301,400.00
210302	Түлш, халаалт	28,500,000.00	28,360,598.00
210303	Цэвэр, бохир ус	3,583,200.00	3,585,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,749,200.00	30,629,400.00
210401	Бичиг хэрэг	12,410,000.00	8,451,000.00
210402	Тээвэр, шатахуун	9,980,000.00	12,325,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,450,000.00	3,538,400.00
210404	Ном, хэвлэл	159,200.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	951,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,750,000.00	5,363,600.00
2105	Нормативт зардал	-	1,500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	87,216,000.00	39,350,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	23,350,000.00	7,599,800.00
210602	Тавилга	38,150,000.00	20,000,000.00

210604	Урсгал засвар	25,716,000.00	11,751,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,072,800.00	6,989,100.00
210702	Дотоод албан томилолт	2,072,800.00	6,989,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,846,200.00	13,827,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,310,000.00	13,148,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	636,900.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	185,700.00	185,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	242,000.00	-
210807	Газрын төлбөр	103,600.00	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,490,300.00	21,258,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,827,200.00	6,258,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,663,100.00	15,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,812,833.25	41,169,269.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	1,340,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	1,340,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,312,833.25	39,829,269.40
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,312,833.25	39,829,269.40
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>5,000,000.00</u>	<u>-</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	5,000,000.00	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	5,000,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,000,000.00	5,000,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	218,880,655.00	49,065,355.32	1,528,392,786.15	1,796,338,796.47
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	218,880,655.00	49,065,355.32	1,528,392,786.15	1,796,338,796.47

C07	Тайлант үеийн үр дүн	-	-	71,554,227.59	71,554,227.59
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	218,880,655.00	49,065,355.32	1,599,947,013.73	1,867,893,024.05
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	218,880,655.00	49,065,355.32	1,599,947,013.73	1,867,893,024.05
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	218,880,655.00	49,065,355.32	1,599,947,013.73	1,867,893,024.05
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(8,876,222.98)	(8,876,222.98)
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	218,880,655.00	49,065,355.32	1,591,070,790.75	1,859,016,801.07

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	723,687,900.00	683,858,630.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	723,687,900.00	683,858,630.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	721,427,900.00	682,518,630.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	509,876,600.00	475,676,479.30
210101	Үндсэн цалин	289,296,700.00	287,842,836.78
210102	Нэмэгдэл	190,903,900.00	151,058,937.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,256,000.00	25,463,574.00
210104	Урамшуулал	-	11,311,131.00
210105	Гэрээт ажлын хөлс	420,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,734,600.00	59,026,053.30
210201	Тэтгэврийн даатгал	43,576,300.00	40,154,513.42
210202	Тэтгэмжийн даатгал	5,039,600.00	4,717,884.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,031,700.00	3,774,307.92
210204	Ажилгүйдлийн даатгал	1,007,900.00	943,576.88
210205	Эрүүл мэндийн даатгал	10,079,100.00	9,435,770.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,247,600.00	36,247,198.00
210301	Гэрэл, цахилгаан	4,301,400.00	4,301,400.00
210302	Түлш, халаалт	28,361,000.00	28,360,598.00
210303	Цэвэр, бохир ус	3,585,200.00	3,585,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,642,400.00	29,642,400.00
210401	Бичиг хэрэг	8,451,000.00	8,451,000.00
210402	Тээвэр, шатахуун	11,338,400.00	11,338,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,538,400.00	3,538,400.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	951,000.00	951,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,363,600.00	5,363,600.00
2105	Нормативт зардал	1,500,000.00	1,500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	39,351,000.00	39,350,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,600,000.00	7,599,800.00
210602	Тавилга	20,000,000.00	20,000,000.00
210604	Урсгал засвар	11,751,000.00	11,751,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,989,100.00	6,989,100.00
210702	Дотоод албан томилолт	6,989,100.00	6,989,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,827,700.00	13,827,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,148,000.00	13,148,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	185,700.00	185,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	450,000.00	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,258,900.00	20,258,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,258,900.00	5,258,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,000,000.00	15,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,260,000.00	1,340,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,260,000.00	1,340,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,260,000.00	1,340,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	723,687,900.00	683,858,630.60
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	723,687,900.00	683,858,630.60
131001	Улсын төсвөөс санхүүжих	723,687,900.00	683,858,630.60
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	5,000,000.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	5,000,000.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,987,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,987,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,987,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	987,000.00
210402	Тээвэр, шатахуун	987,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,987,000.00

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,987,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,987,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Прокурорын газар нь Монгол Улсын Үндсэн хууль, Зөрчлийн тухай хууль, Захиргааны хэргийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, дээд шатны байгууллага, албан тушаалтны тогтоол, шийдвэр, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой хөтөлбөр, төлөвлөгөө, хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- ✓ *Нутаг дэвсгэртээ хууль тогтоомжийг хэрэгжүүлэх*
- ✓ *Засгийн газрын шийдвэр болон харьяалах дээд шатны шийдвэрийг гүйцэтгэлийг хянах*
- ✓ *Харьяа яамны сайдын тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх*

Прокурорын ерөнхий газрын 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/04 тоот тушаалаар батлагдсан орон тоогоор ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ✓ *Төрийн хэмнэлтийн тухай хууль*

Тайлант онд Прокурорын газар нь хүний эрхийг дээлэн, үйл ажиллагаандаа иргэдийн оролцоо, дэвшилтэд технологийн ашиглалтыг нэмэгдүүлэн албан хаагчдын эрүүл мэнд, хууль ёсны эрх ашгийг хамгаалж хүний нөөцийн тогтвортой байдлыг бүрдүүлж ажиллана гэсэн зорил дэшүүлэн, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган үр дүнг тооцон ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Захиргааны ерөнхий хууль, Төрийн албаны тухай хууль, Зөрчлийн тухай хууль,Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль зэрэг бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт **үр нөлөөтэй** байна.

Байгууллагын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна. Тайлант онд тус ажлын хэсэг 2 ажлыг төлөвлөн хэрэгжүүлжээ.Прокурорын ерөнхий газраас дотоод аудит, хяналт, шинжилгээ үнэлгээний газраас тус онд дотоод хяналт шалгалт хийгдсэн байна.

Тайлант онд ТӨБЗГ-ын 2022 оны 02 дугаар 22-ны өдрийн 64 дүгээр тогтоолын дагуу төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсэг 5

хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, тооллогыг зохион байгуулж хөрөнгө бүртгэн авах, актлах хөрөнгийг шийдвэрлүүлэх талаар санал дүгнэлтийг гаргажээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Прокурорын газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Прокурорын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8.8 сая төгрөгөөр буюу 1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	5,000.0	5,000.0	-
Авлага	387.1	-	(387.1)
Бараа материал	13,881.2	13,956.6	75.4
Үндсэн хөрөнгө	1,853,624.7	1,845,060.2	(8,564.5)
Нийт хөрөнгө	1,872,893.0	1,864,016.8	(8,876.2)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,872,893.0	1,864,016.8	(8,876.2)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,872,893.0	1,864,016.8	(8,876.2)

Дээрх хүснэгтээс харахад дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Бараа материалын дансанд төсвийн хөрөнгөөр 75.4 сая төгрөгийн хөрөнгө авч бүртгэж авснаар бараа материалын үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн байна.
- ✓ Үндсэн хөрөнгийн зардал МУЕП-ын А/62, 101 тоот тушаалаар үлдэх өртөггүй хөрөнгө акталсан, элэгдлийн зардалтай холбоотой буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 715.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 1.8 сая төгрөгөөр бууруулж 713.4 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2022 оны төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй эсвэл өмнөх оны төсвийн гүйцэтгэлд үндэслэснээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг тодотгоогүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 723.4 сая төгрөг бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 723.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж 683.6 сая төгрөг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 683.6 сая төгрөг буюу 97 хувьтай зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70704/80101-Зардал	721,427.9	681,598.6	39,829.3	94
2	70711/80802-Тэтгэвэр, тэтгэмж	2,260.0	2,260.0	-	100
ДҮН		723,687.9	683,858.6	39,829.3	97

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар хоорондын тооцоогоор ИТХ-аас 1.9 сая төгрөг оруулж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 1.9 сая төгрөг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Прокурорын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Д.Эрдэнэцэцэг 2023 оны 02 дүгээр сарын 16-наас 02 дүгээр сарын 19-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/75 албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт хөрөнгийн дүнгээс 1864.0 сая төгрөгөөс 1 хувиар буюу 18.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 13.0 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

9 дүгээр зүйлд заасан албан томилолтын хувьд тус байгууллага нь 2022 онд 6.9 сая төгрөгийн томилолтын зардлыг давхардсан тоогоор 8 албан хаагчид олгосон байна. Энэ нь гүйцэтгэх албан тушаалтан Улаанбаатар хотод мэргэжлийн сургалтад оролцох, албан хаагчид хяналт шалгалт хийх зэрэг ажлаар ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 145 мэдээллээс хугацаандаа оруулсан 145 мэдээлэл бүрэн оруулж хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд залруулга хийгдсэнгүй

Аудитаар алдаа зөрчил илэрсэнгүй

5.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт бичигдээгүй

5.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй

5.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдсөнгүй

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Залруулга хийгдээгүй												
Дүн	-	-			-	-	-	-				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Үүнээс										
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
Алдаа зөрчил илэрсэнгүй	-	-									
Дүн	-	-	-	-	-	-	-	-			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										

Алдаа илрээгүй	-	-	-	-	-	-	-	-
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Алдаа илрээгүй								
Дүн								
Нийт дүн								


АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БАЯНБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:

 Д.ЭРДЭНЭЦЭЦЭГ
 847743692
 9066454